



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 9 сарын 0 өдөр

Дугаар 395

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1.а дахь заалт, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 18 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлалтай, Тк844 худгаас Тк860 худаг хүртэлх дулааны төв 8Д магистраль шугамын өргөтгөлийн ажлын хүрээнд бий болсон нийт 5,552,952,131.00 (таван тэрбум таван зуун тавин хоёр сая есөн зуун тавин хоёр мянга нэг зуун гучин нэг) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг “Улаанбаатар дулааны сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга З.Мэндсайхан, “Улаанбаатар дулааны сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Д.Бямба-Очир нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Комисс томилон хөрөнгө хүлээн авч бүртгэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.


ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА



Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2018 оны 9 дүгээр сарын 19-ны өдрийн
 395 дугаар тогтоолын хавсралт

**"Улаанбаатар дулааны сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанийн
 дансанд бүртгэх барилга байгууламж**

Д/д	Хөрөнгийн нэр	Хүчин чадал			метр	Барилга байгууламжийн хугацаа		Захиалагч байгууллага	Гүйцэтгэгч байгууллага	Гэрээний дугаар	Улсын комиссын акт дугаар	Төсөвт өртөг (төгрөг)
		хэм жиж нэгж	биет хэмжээ	Эхэлсэн		Дууссан						
1	Сонгинохайрхан дүүргийн 8Д магистраль Тк844 худгаас Тк860 худаг хүртэлх дулааны төв шугам	хос метр	ф600	3528	2017	2017	Эрчим хүчний яам	"САН" ХХК	ЭХА-16/2017	2017-12-21 55/2017	5,552,952,131.00	
Нийт дүн												5,552,952,131.00 (таван тэрбум таван зуун тавин хоёр сая есөн зуун тавин хоёр мянга нэг зуун гучин нэг)